

мөн. Энэ талаар сургалт явуулах, туршлага судлуулах, зөвлөгөө өгүүлэх, эрдэм шинжилгээний ажил явуулах зэрэг их ажил бий. Өмч хувьчлалын сангийн хөрөнгийг бусдад зээлдүүлэхийн оронд ийм арга хэмжээнд зориулж байсан бол илүү үр дүнтэй байж магадгүй билээ.

Хувьцаат компани болон бусад хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн байдлыг төр хараа хяналтаасаа гаргаж орхимгүй байна. Тэдгээртэй ажилладах, дэмжиж туслан, зөвлөдөг зохион байгуулалтын бүтцийг бий болгох нь зүйтэй.

БАРИМТ БИЧИГ,  
ЛАВЛАХ

**“МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО  
1990-ЭЭД ОНД” ОНОЛ ПРАКТИКИЙН  
БАГА ХУРЛЫН ЗӨВЛӨМЖ**

Бага хурал 1994 оны 6 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд болж, гадаад харилцаанд оролцогч төр, засаг, олон нийтийн байгууллагуудын төлөөлөгчид, дипломатууд оролцов.

Бага хурлаас доорх зөвлөмжийг гаргав. Үүнд:

**1. Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарах бодлогын чанартай зарим асуудал**

1. Гадаад бодлогын үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, энэ зорилгоор гадаад харилцааны болон шинжилгээ, судалгааны байгууллагуудын ажлын хэлхээ холбоог оновчтой болгох.

2. Манай улсын эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулж, хэрэгжүүлэх,

3. Дипломат албаны тухай хуулийг боловсруулж гаргуулах,

4. Үндэснийхээ аюулгүй байдлыг улс төрийн аргаар бүх талаас нь хангах хэрэгт НҮБ-ын боломжийг оновчтой ашиглах талаар санал зөвлөмж боловсруулах.

5. Ази, Номхон далайн бүс нутгийн гол улс орнуудтай хоёр талын харилцаа, түүний дотор худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар бүсийн орнуудын олон талын хамтын ажиллагаанд анхаарлаа чиглүүлэх.

6. Эх орныхоо байгалийн өвөрмөц онцлогийг хөгжлийн зорилгод ашиглах, дэлхийн байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд дөхөм болгох зорилгоор НҮБ-ын хүрээлэн буй орчны хөтөлбөртэй хамтран ажиллах. Шим ертөнцийн удмын сангийн чухал

нөөцтэй Монгол Улсын экологийн аюулгүй байдлыг хангах зорилтыг дэлхийн экологийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болон уялдуулах чиглэлээр ажиллах.

7. Монгол, Орос, Хятадын гурван талын хамтын ажиллагааны механизм буй болгох асуудлыг судалж дүгнэлт гаргах.

8. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнөөс олон улсын харилдааг ардчилах, эдийн засгийн харилцааны шударга дэг журам тогтоох талаар тавьж буй хүч чармайлтад оновчтой оролцох.

9. Монгол Улсыг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан статусаа бататгах хууль гаргах асуудлыг судалж дүгнэлт гаргах.

10. Ази-Номхон далайн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг олон нийтийн байгууллагууд, тухайлбал Ази-Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны Зөвлөл /CSCAP/-д элсэн орох асуудлыг судалж дүгнэлт гаргах.

11. Шинэ нөхцлийн шардлагыг хангаж чадах гадаад харилцааны мэргэжилтэй боловсон хүчнийг өөрийн нөхцөл, уламжлал дээр сурган бэлтгэх арга хэмжээ авах.

12. Далайд гарцгүй орнуудад олон улсын гэрээ, конвенцийн дагуу үзүүлдэг хөнгөлөлтийг бүрэн ашиглах талаар судалж дүгнэлт гаргах.

13. Олон улсын харилдааны дээд сургуулийг бэхжүүлэх талаар тодорхой ажил зохиох, тухайлбал олон улсын байгууллага, гадаадын ижил төстэй сургуулиудаас тусламж дэмжлэг авах боломжийг идэвхтэй хайх.

14. Олон улсын харилцааны онол, тулгамдсан асуудлуудаар гадаадын нэртэй эрдэмтдийн оролцоотойгоор үндэсний симпозиум, семинар зэргийг зохиож байх.

15. Гадаад харилцааны тодорхой асуудлаар санал солилцох янз бүрийн хэлбэрийн уулзалт үе үе хийж байх.

## 2. Тодорхой авч үзэх зарим асуудал

-Гадаад харилцаанд оролцогч байгууллгуудын үйл ажиллагааг зохицуулан чиглүүлж байх талаар Гадаад харилцааны яамны эрх, үүргийг өнөөгийн нөхцөлтэй уялдуулан авч үзэх.

-Монгол Улсын гадаад сурталчилгааны ажлыг шинэ нөхцөлд нийцүүлэн идэвхижүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах.

-НҮБ, түүний системийн байгууллагуудад хуримтлагдсан мэдээлэл, судалгаа шинжилгээний материалуудаас ашиглах, тухайлбал гадаад өрийн асуудал, хүүхэд, эмэгтэйчүүдийн нийгмийн байдлыг сайжруулах зэрэг салбарт оновчтой ашиглах арга олох.

-Монгол Улсын зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах хүчний байлдааны бус үйл ажиллагаанд оролцох боломжийн талаар судалж дүгнэлт гаргах.

-ЮНИТАР болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран Монгол Улсын хөгжлийн тулгамдсан зарим асуудлаар олон улсын семинар, симпозиум зохиох боломжийг судлах, тухайлбал Монгол Улсын шинэчлэлийн асуудлаар үндэсний симпозиум 1995 он зохиох боломжийг судлах.

**МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН  
ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ  
/1994 оны эхний хагас жил/**

**1994.01.01.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд П. Жасрай нар Кубын үндэсний баярыг тохиолдуулан Бүгд Найрамдах Куба Улсын Төрийн Зөвлөлийн дарга, Засгийн газрын тэргүүн Фидель Кастро Руст баяр хүргэсэн цахилгаан утас илгээв.

**1994.01.11.** Японы Омияа хотод болсон үзэсгэлэнд оролцсон Монголын зураач Ж. Саруулбуян, С. Цогтбаяр нарын бүтээлүүд “Японы шилдэг зургууд” номд хэвлэгдсэн байна.

**1994.01.12.** Японы монголч эрдэмтэн Т. Мацуда Монголын зохиолчдын эвлэлийн 65 жилийн ойг тохиолдуулан баярын цахилгаан утас ирүүлжээ. Тэрбээр Монголын уран зохиолын хөгжилтөд амжилт хүсээд яруу найргийн “Болор цом-94” наадамд түрүүлсэн шүлэгчийг Японд долоо хоногийн хугацаатай жуулчлуулахаар амлав.

**1994.01.14.** Монгол, Японы хамтын нөхөрлөлийн хөдөлгөөн Хууль зүйн яаманд бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авав.

**1994.01.18.** Хоёр орны харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийн дагуу Японы Гадаад хэргийн яам жил бүр Монголоос 35 хүртэл насны залуу албан хаагчдыг урьдаг болжээ.

**1994.01.19.** Зураач Д. Гунгаа, С. Энх-Амгалан нарын бие даасан үзэсгэлэн Италийн Милан хотноо нээгджээ.